

Сүлжээний Зааварчилгаа

Агуулга

Танилцуулга

Мэдэгдэл.	3
Энэхүү гарын авлагын тухай.	3
Анхааруулга, Чухал мэдээлэл болон Тэмдэглэл.	3
Үйлдлийн Системийн Хувилбар.	3
Сүлжээний Үндсэн ойлголтууд.	4
Wi-Fi (утасгүй) сүлжээ.	4
Этернэт (утаастай) сүлжээ.	7

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

Холболтын Аргыг Өөрчлөх.	8
Сүлжээний Төхөөрөмжөөс.	8
Windows.	8
Mac OS X.	11
Ухаалаг утас буюу таблет (iOS/Android)	11
Бүтээгдэхүүнийг Wi-Fi сүлжээнд гар аргаар холбох.	12
Wi-Fi тохуруулгын визард.	12
Wi-Fi Protected Setup (WPS).	13
Шууд Холболт.	13
Wi-Fi Direct.	14
Ад хок горим.	16

Асуудал шийдвэрлэх

Сүлжээний Асуудлыг Шийдэх Зөвлөгөө.	22
Сүлжээний холболтын шалгалтын тайланг хэвлэх.	22
Сүлжээний төлвийг гаргах болон сүлжээний төлвийн хуудсыг хэвлэх.	22
Wi-Fi тохиргоог цуцлах болон эхлүүлэх	23
Бүтээгдэхүүний фирмварийг шинэчлэх	23
Холболтыг Пинг команд ашиглан шалгах.	24
Тохируулгын Асуудал.	25
Wi-Fi-д холбогдох.	25
Wi-Fi Direct-д холбогдох.	26
Этернэтэд холбогдох.	27
Wi-Fi эсвэл Этернэтэд холбогдох.	29
Хэвлэлтийн Асуудлууд.	30
Wi-Fi-д Холбогдсон Компьютер.	30

Этернэтэд Холбогдсон Компьютер.	30
Wi-Fi эсвэл Этернэтэд Холбогдсон Компьютер.	31
Ухаалаг утас буюу таблет.	31
Сканнердах үеийн Асуудлууд.	31
Wi-Fi эсвэл Этернэтэд холбогдох.	31
Үйлдлийн Систем Тус бүрт хамаарах Асуудлууд.	32
IPv4/IPv6 функцыг хүснэгт.	32
Mac OS X.	33
iOS.	34
Android.	35
Програм хангамжийн Асуудлууд.	35
EpsonNet Print-ээр хэвлэж байх үед утасны шугаман холболтын харилцах хайрцаг гарч ирсэн.	35
Epson програм хангамжийн блокийг болиулах.	35
Бусад Асуудлууд.	36
Бүтээгдэхүүн дээр сүлжээний үйлчилгээг тохируулах боломжгүй байх, эсвэл гэнэт сүлжээний үйлчилгээг хэрэглэх боломжгүй болсон.	36

Сүлжээний Үзүүлэлтүүдийн Зохиогчийн эрх болон Лиценз

Зохиогчийн эрх, Худалдааны тэмдэг болон Лиценз.	37
Info-ZIP copyright and license.	37
НЭЭЛТТЭЙ ЭХИЙН ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ЛИЦЕНЗ.	38

Танилцуулга

Мэдэгдэл

Энэхүү гарын авлагын тухай

Энэхүү Сүлжээний Зааварчилгаа нь сүлжээний функц бүхий бүтээгдэхүүнүүдийн ерөнхий гарын авлага болно. Гарын авлагыг хэрэглэхдээ дараах зүйлийг анхаарна уу.

- LCD дэлгэц, Wi-Fi/Этернэт функц, сканнерын функц зэрэг ашиглах боломжтой функцууд болон төхөөрөмжүүд нь таны бүтээгдэхүүнээс хамаарч ялгаатай байж магадгүй.
- Гарын авлагад ашигласан LCD дэлгэцийн агшин болон програм хангамж нь ерөнхий жишээ болно. Цэс, товчны нэр, дэлгэцний агшин нь таны бүтээгдэхүүнээс хамаарч ялгаатай байж магадгүй.
- Гарын авлагын агуулга болон бүтээгдэхүүний үзүүлэлтүүдийг гурьдчилж мэдэгдэлгүйгээр өөрчилж болно.

Анхааруулга, Чухал мэдээлэл болон Тэмдэглэл

Энэхүү гарын авлага дахь Анхааруулга, Чухал мэдээлэл болон Тэмдэглэл нь доорх байдлаар гарч ирэх ба дараах утгыг илэрхийлнэ.

**Анхааруулга**

биед гэмтэл учрахаас сэргийлж анхааралтай дагаж мөрдөх шаардлагатай.

**Чухал мэдээлэл**

төхөөрөмжид эвдрэл үүсэхээс сэргийлж унших шаардлагатай.

Тэмдэглэл

бүтээгдэхүүний ажиллагааны тухай хэрэгцээтэй зөвлөгөө, хязгаарлалтыг агуулна.

Үйлдлийн Системийн Хувилбар

Энэхүү гарын авлагад дараах товчилсон үгс хэрэглэгдэнэ.

- Windows 8.1 нь Windows 8.1 болон Windows 8.1 Pro-ийг төлөөлнө.
- Windows 8 нь Windows 8 болон Windows 8 Pro-ийг төлөөлнө.
- Windows 7 нь Windows 7 Home Basic, Windows 7 Home Premium, Windows 7 Professional, болон Windows 7 Ultimate-ийг төлөөлнө.

Танилцуулга

- ❑ Windows Vista нь Windows Vista Home Basic Edition, Windows Vista Home Premium Edition, Windows Vista Business Edition, Windows Vista Enterprise Edition, болон Windows Vista Ultimate Edition-ийг төлөөлнө.
- ❑ Windows XP нь Windows XP Home Edition, Windows XP Professional x64 Edition болон Windows XP Professional-ийг төлөөлнө.
- ❑ Mac OS X v10.9.x нь OS X Mavericks-ыг төлөөлөх ба Mac OS X v10.8.x нь OS X Mountain Lion-ыг төлөөлнө. Мөн, Mac OS X нь Mac OS X v10.9.x, Mac OS X v10.8.x, Mac OS X v10.7.x болон Mac OS X v10.6.x-ийг төлөөлнө.

Сүлжээний Үндсэн ойлголтууд

Энэхүү гарын авлагад гарч ирэх сүлжээний холболтуудыг доор тайлбарлана. Таны бүтээгдэхүүнээс хамаарч сүлжээний холболтын бүх төрлийг ашиглах боломжгүй байж магадгүй.



Wi-Fi (утасгүй) сүлжээ

Wi-Fi холболтын гурван төрөл бий; Дэд бүтцийн горим (рүүтэр буюу хандалтын цэгээр дамжин холбогдох), Wi-Fi Direct (хандалтын цэг ашиглалгүй төхөөрөмжтэй шууд холбогдох), болон Ад Хок.

Танилцуулга

Дэд бүтцийн горим (Хандалтын цэгээр дамжин холбогдохын тулд)

Дэд бүтцийн горимд, утасгүй болон утастай компьютерүүд бүгд (утасгүй рүүтэр зэрэг) хандалтын цэгээр дамжин холбогдож сүлжээний интерфэйс рүү өгөгдлийг илгээх боломжтой.



- a. бүтээгдэхүүн
- b. Утасгүй рүүтэр (эсвэл хандалтын цэг)
- c. Wi-Fi интерфэйстэй компьютер (цаанаасаа суулгагдсан эсвэл USB/PC карт зэргээр нэмж суулгасан)
- d. LAN порт буюу Wi-Fi интерфэйстэй компьютер
- e. Этернет кабел (хэрэв компьютер болон утасгүй рүүтэрийг шууд холбох бол)
- (f. Интернэт хандалт)

Танилцуулга

Wi-Fi Direct (Хандалтын цэг ашиглалгүй шууд холбогдохын тулд)

Бүтээгдэхүүнийг хандалтын цэггүйгээр утасгүй орчинд ашиглахын тулд Wi-Fi Direct холболтыг ашиглана.

Хэрэв бүтээгдэхүүн Wi-Fi Direct функцтай бол хандалтын цэг ашиглалгүйгээр утасгүй холбох боломжтой.

Илүү дэлгэрэнгүйг [14 хуудас дээрх "Wi-Fi Direct"](#) -ээс лавлана уу.



a. бүтээгдэхүүн (цаанаасаа суулгагдсан Wi-Fi Direct функц)

b. (Wi-Fi интерфэйстэй) компьютер эсвэл Wi-Fi төхөөрөмж

Ад хок горим (Хандалтын цэг ашиглалгүй шууд холбогдохын тулд)

(Утасгүй рүүтэр зэрэг) хандалтын цэггүйгээр бүтээгдэхүүнийг утасгүй орчинд ашиглаж болох өөр арга нь Ад Хок горимыг ашиглах юм. Илүү дэлгэрэнгүйг [16 хуудас дээрх "Ад хок горим"](#) -ээс лавлана уу.




a. бүтээгдэхүүн

b. Wi-Fi интерфэйстэй компьютер (цаанаасаа суулгагдсан эсвэл USB/PC карт зэргээр нэмж суулгасан)

Этернэт (утаастай) сүлжээ

Утаастай сүлжээний холболтын хувьд, хаб/рүүтэрийг бүтээгдэхүүнд Этернэтийн кабел ашиглан холбоно.



Утаастай сүлжээнд шаардлагатай техник хангамж

- a. бүтээгдэхүүн
- b. Этернэт кабел
- c. Этернэт ХАБ
- d. LAN порттой компьютер
- e. Рүүтэр
- (f. Интернэт хандалт)

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

Энэ хэсэгт бүтээгдэхүүнийг хэрхэн сүлжээгээр ашиглах болон бүтээгдэхүүний холболтын аргыг Windows, Mac OS X, iOS, Android-ыг ажиллуулж байгаа төхөөрөмжөөс хэрхэн өөрчлөхийг тайлбарлана. Бүтээгдэхүүнийг анх удаа тохируулах талаарх дэлгэрэнгүйг бүтээгдэхүүний Эндээс Эхлэ-ээс лавлаарай.

Холболтын Аргыг Өөрчлөх

Бүтээгдэхүүнийг хэрхэн холбогдох аргыг өөрчлөх арга нь өмнөх холболтоос хамаарч ялгаатай байна.

- USB, Этернэт болон шууд холболтоос Wi-Fi руу:**
Үйлдлийн систем тус бүрийн тайлбарыг дараагийн хэсэгт харна уу.
- Wi-Fi-аас Этернэт рүү:**
Холболтын аргыг өөрчлөхийн өмнө, тохиргоог Этернэт рүү солих буюу бүтээгдэхүүний хянах самбараас Wi-Fi-г хаа. Windows болон Mac OS X-т зориулсан зааврыг дараах хэсгээс харна уу.

Сүлжээний Төхөөрөмжөөс

Windows

Бүтээгдэхүүний програм хангамжийн дискийг ашиглан тохируулах


Бүтээгдэхүүнийг Windows компьютерээс хэрэглэхийн тулд, програм хангамжийн дискийг нь ашиглан тохируулна. Та мөн бүтээгдэхүүнийг хоёрдогч компьютерээс хэрэглэх, эсвэл USB холболтоос сүлжээний холболт руу солихыг хүсвэл програм хангамжийн дискийг ашиглах боломжтой.

Хэрэв таны компьютерт CD/DVD тоглуулагч байхгүй бол, суулгагчийг өөрийн бүсийн Epson Вэб сайтаас татах боломжтой.

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

Тэмдэглэл:

- ❑ Компьютерийн тохируулгыг эхлүүлэхийн өмнө, рүүтэр, утасгүй адаптар, хаб зэрэг сүлжээний төхөөрөмжүүд зөв ажиллаж байгаа эсэхийг шалгаад санах ойн картыг бүтээгдэхүүнээс гарга.
- ❑ Хэрэв таны үйлдлийн систем эсвэл програмын аюулгүй байдлын анхааруулах дэлгэц гарч ирвэл, **Unblock (Блок цуцлах)** буюу **Allow (Зөвшөөрөх)**-ийг дарж Галт ханын онцгой тохиолдлыг үүсгэ.
Арилжааны аюулгүй байдлын програм хангамжийн дэлгэц дээрх **Keep Blocking (Үргэлжлүүлэн Блоглох), Block (Блоклох)** буюу бусад адил төстэй командыг бүү дараарай.
Ашиглаж буй арилжааны аюулгүй байдлын програм хангамжаас хамаарч дээрх үйлдлээр холболт үүсгэх боломжгүй байж болзошгүй. Энэ тохиолдолд, аюулгүй байдлын програмыг түр хаагаад бүтээгдэхүүний програмыг ажиллуулаарай.



1 Бүтээгдэхүүнийг асааж Wi-Fi/Этернэт хэвийн ажиллаж байгаа эсэхийг магадла.

2 Програмын дискийг CD-ROM/DVD тоглуулагчид оруул.

Тэмдэглэл:

Хэрэв Windows дээр суулгалтын дэлгэц автоматаар гарч ирэхгүй бол, **Computer (Компьютер)** (эсвэл **My Computer (Миний Компьютер)**) дахь Диск таних тэмдгийг хоёр дар.

3 Дэлгэцэн дээрх зааварчилгааг дага.

WSD-ийг ашиглан тохируулах (Windows 8.1/8/7/Vista-д)

Энэ бүтээгдэхүүн нь Web Services on Devices (Төхөөрөмжийн веб үйлчилгээ) (WSD)-ийг дэмждэг. Бүтээгдэхүүний холбогдсон сүлжээнд хоёрдогч компьютерыг нэмэхийг эсвэл олон компьютерыг зэрэг тохируулахыг хүсвэл WSD-ийг ашиглах нь тохиромжтой.

Тэмдэглэл:

- ❑ Принтер/сканнерыг WSD-аар тохируулахын тулд, компьютер болон бүтээгдэхүүнийг сүлжээнд холбосон байх шаардагатай.
Бүтээгдэхүүний хянах самбараас сүлжээний холболтыг тохируулах талаар дэлгэрэнгүйг [12 хуудас дээрх "Бүтээгдэхүүнийг Wi-Fi сүлжээнд гар аргаар холбох"](#) -ээс лавлаарай.
- ❑ Принтер/сканнерыг WSD-аар тохируулахын өмнө драйверыг суулгах шаардлагатай.

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

1 Бүтээгдэхүүн асаалттай эсэхийг нягтал.

Тэмдэглэл:

Windows 8.1/8 нь WSD драйверыг автоматаар суулгадаг тул 2-оос 5 хүртэлх алхамыг алгасч болно.

2 Windows 7-ийн хувьд: **Start (Эхлэл), Computer (Компьютер)**-ийг дараад, **Network (Сүлжээ)**-г дар.

Windows Vista-ийн хувьд: **Start (Эхлэл)**-ийг дараад **Network (Сүлжээ)**-г дар.

3 Бүтээгдэхүүний таних тэмдгийг баруун товчоор дараад **Install (Суулгах)**-ыг дар.

User Account Control (Хэрэглэгчийн Данс Хянагч) дахь **Continue (Үргэлжлүүлэх)**-ийг дар.

Тэмдэглэл:

Таних тэмдэг сүлжээний бүтээгдэхүүний нэрийг харуулна (жишээ нь, EPSONXXXXXX (таны бүтээгдэхүүний нэр)). Бүтээгдэхүүний нэрийг хянах самбар эсвэл сүлжээний төлвийн хуудаснаас магадлах боломжтой. Хянах самбар дээр магадлах буюу сүлжээний төлвийн хуудсыг хэвлэх талаарх дэлгэрэнгүйг [22 хуудас дээрх "Сүлжээний төлвийг гаргах болон сүлжээний төлвийн хуудсыг хэвлэх"](#) -ээс лавлаарай.

Хэрэв **Install (Суулгах)**-ийг оронд **Uninstall (Устгах)** гарч ирвэл, **Uninstall (Устгах)**-ийг нэг удаа дараад дахин оролдож үзээрэй (Windows 7 болон Vista дээр).

4 **Your devices are ready to use (Таны төхөөрөмжүүд ашиглахад бэлэн) (Your device is ready to use (Таны төхөөрөмж ашиглахад бэлэн))**-ийг дар.

Тэмдэглэл:

Windows 7 хэрэглэгчдэд зориулсан тэмдэглэл: Алхам 4 болон 5-ийг алгас.

5 Дэлгэцийг шалгаад **Close (Хаах)**-ийг дар.

6 Windows 8-ийн хувьд: **Desktop (Үндсэн дэллгэц) > Settings (Тохиргоо)** Дүр төрх > **Control Panel (Хянах Самбар)**-ийг сонгоод дараа нь **View devices and printers (Төхөөрөмж болон принтерүүдийг харах)**-ийг сонго.

Windows 7-ийн хувьд: **Start (Эхлэл)**-ийг дараад **Devices and Printers (Төхөөрөмж болон Принтерүүд)**-ийг дар.

Windows Vista-ийн хувьд: **Start (Эхлэл)** товчийг дараад, **Network (Сүлжээ)**-г дар.

Windows 8 хэрэглэгчдэд зориулсан тэмдэглэл:

Хэрэв бүтээгдэхүүний таних тэмдгийг олохгүй бол доорх алхамуудыг гүйцэтгэ.

1. **Add a device (Төхөөрөмж нэмэх)**-ыг сонго.
2. Бүтээгдэхүүнээ сонгоод **Next (Дараах)**-ийг дар.
3. Дэлгэцэн дээрх зааварчилгааг дага.

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

- 7** Сүлжээний бүтээгдэхүүний нэр бүхий таних тэмдэг (жишээ нь, EPSONXXXXXX (таны бүтээгдэхүүний нэр)) нэмэгдсэн эсэхийг магадла.

WSD ашиглан хэвлэхийн тулд, бүтээгдэхүүнийг сүлжээний бүтээгдэхүүний нэрээр нь сонго.

Тэмдэглэл:

- Сканнын функцыг WSD-аар ашиглахын тулд Windows 8.1/8/7/Vista дээр **Windows Fax and Scan (Windows Факс болон Скан)** эсвэл **Paint (Зурах)**-ийг хэрэглээрэй.
- Windows 8.1/8/7/Vista дээр **Windows Fax and Scan (Windows Факс болон Скан)** эсвэл **Paint (Зурах)**-ийн сонгосон сканнерын нэр нь сүлжээний бүтээгдэхүүний нэртэй адил байна.
- Арилжааны програм хангамж ашиглах тохилдолд, сканнердах дарааллыг програмтай цуг ирсэн Хэрэглэгчийн Зааварчилгаа-наас лавлаарай.

Mac OS X

Бүтээгдэхүүнийг сүлжээнд холбох

Mac OS X -ийн хувьд, програмын Epson Вэб сайтаас татаарай.

Тэмдэглэл:

- Сүлжээний тохируулгыг эхлэхээс өмнө, бэхний гэрийг цэнэглэх, хэлийг тохируулах зэрэг анхан шатны тохиргоонуудыг дуусга.
- Компьютерийн тохируулгыг эхлүүлэхийн өмнө, рүүтэр, утасгүй адаптар, хаб зэрэг сүлжээний төхөөрөмжүүд зөв ажиллаж байгаа эсэхийг шалгаад санах ойн картуудыг бүтээгдэхүүнээс гарга.

- 1** Хэрэв Этернэт сүлжээнд холбогдохыг хүсвэл, LAN кабел ашиглан бүтээгдэхүүнийг хаб руу холбо.

- 2** Дараах холбоосыг дарж дэлгэц дээрх зааварчилгааг дага.
<http://epson.sn> эсвэл <http://support.epson.net/setupnavi/>

Ухаалаг утас буюу таблет (iOS/Android)

Epson iPrint нь танд ухаалаг утас буюу таблет (iOS/Android)-аасаа бүтээгдэхүүн рүү утасгүй хэвлэж, сканнердах боломжийг олгоно. Хэрэв таны бүтээгдэхүүн Wi-Fi сүлжээнд холбогдоогүй бол бүтээгдэхүүний хянах самбарыг ашиглан Wi-Fi сүлжээнд гар аргаар холбо. Гар аргаар тохируулгын талаарх дэлгэрэнгүйг [12 хуудас дээрх "Бүтээгдэхүүнийг Wi-Fi сүлжээнд гар аргаар холбох"](#) -ээс лавлаарай.

Тэмдэглэл:

- Бүтээгдэхүүнд холбохоосоо өмнө, ухаалаг утас буюу планшетаа сүлжээнд холбогдсон эсэхийг шалга.
- Хэрэв та зөвхөн Этернэт функцтай бүтээгдэхүүнийг ухаалаг утас буюу планшетаас хэрэглэхийг хүсвэл, тухайн бүтээгдэхүүнийг утасгүй рүүтэр (хандалтын цэг)-т LAN кабел ашиглан холбоорой.

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

Epson iPrint-г Ашиглах

- 1 "Epson iPrint"-ийг App Store (iOS) эсвэл Google Play (Android)-оос ухаалаг утас буюу таблет руугаа татаарай.
Та мөн Epson iPrint-г дараах Epson Вэб сайтаас татаж авах боломжтой.



<http://ipr.to>

- 2 Epson iPrint-г эхлүүлээд, хэрэглэхийг хүссэн бүтээгдэхүүнээ хайж тохируул.

Тэмдэглэл:

Epson iPrint тохиргооны талаар дэлгэрэнгүй мэдээллийг Epson iPrint,-ийн дагалдах Тусламж эсвэл Epson Connect Вэб портал сайтаас лавлаарай.

<https://www.epsonconnect.com/> (Epson Connect портал сайт)

<http://www.epsonconnect.eu/> (зөвхөн Европ)

Бүтээгдэхүүнийг Wi-Fi сүлжээнд гар аргаар холбох

Бүтээгдэхүүнийг хянах самбар ашиглан сүлжээнд холбохын тулд доорх алхамуудыг гүйцэтгэ.

Тэмдэглэл:

- Сүлжээний тохируулгыг эхлэхээс өмнө, бэхний гэрийг цэнэглэх, хэлийг тохируулах зэрэг анхан шатны тохиргоонуудыг дуусга.
- Бүтээгдэхүүнийг холбохын өмнө Wi-Fi сүлжээгээ нээлттэй байгаа эсэхийг шалгаарай.

Wi-Fi тохируулгын визард

Хэрэв таны бүтээгдэхүүн LCD дэлгэцтэй бол Wi-Fi Setup Wizard-г ашиглан гар аргаар тохируулгыг хялбарчлах боломжтой. LCD дэлгэц дээр Wi-Fi сүлжээнийхээ SSID болон нууц үгийг оруулан тохируулах боломжтой. Энэ үзүүлэлтийг зөвхөн LCD дэлгэцтэй бүтээгдэхүүн дээр л ашиглах боломжтой.

Тэмдэглэл:

- Энэ тохиргоо нь бүх бүтээгдэхүүнд ашиглагдах боломжгүй эсвэл идэвхжээгүй байж магадгүй.
- Wi-Fi тохируулгын үед шаардлагатай учраас сүлжээнийхээ SSID болон нууц үгийг шалгаарай. Хэрэв SSID болон нууц үгийг мэдэхгүй бол сүлжээний администратороосоо шалга.

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

Wi-Fi Setup Wizard ашиглан Wi-Fi холболтыг тохируулах талаарх мэдээллийг авахын тулд дараах холбоосыг дарна уу. Энэ үзүүлэлт нь бүх бүтээгдэхүүнд ашиглагдах боломжгүй эсвэл идэвхжээгүй байж магадгүй.

 <html/wizard.htm>

Wi-Fi Protected Setup (WPS)

Хоёр төрлийн Wi-Fi Protected Setup (WPS) бий; WPS товчлуурын арга болон WPS PIN кодны арга. Эдгээр аргууд нь LCD дэлгэцгүй бүтээгдэхүүнүүдэд ашиглагдах боломжтой.

Тэмдэглэл:

- Энэ тохиргоо нь бүх бүтээгдэхүүнд ашиглагдах боломжгүй эсвэл идэвхжээгүй байж магадгүй.
- Бүтээгдэхүүнийг сүлжээнд холбохоос өмнө, хандалтын цэг WPS функцыг дэмжих эсэхийг шалга.
- Хэрэв хандалтын цэг (утасгүй рүүтэр) ойролцоогоор хоёр минутын дотор танигдахгүй бол алдааны зурвас гарч ирнэ. Энэ тохиолдолд, хандалтын цэг ажиллагаатай байгаа эсэхийг магадлаад, WPS тохиргоог эхнээс нь хий.
- Хандалтын цэгийн WPS функц буюу асуудал шийдвэрлэх талаарх дэлгэрэнгүйг хандалтын цэгийн хэрэглэгчийн гарын авлагаас лавлаарай.

WPS товчлуур

Утасгүй рүүтэр (хандалтын цэг) дээрх WPS товчийг дарж тохируулгыг хийх боломжтой. Хэрэв аль хэдийн өөр Wi-Fi идэвхжсэн төхөөрөмжийг WPS ашиглан холбосон бол үүнийг сонгоорой.

WPS тохируулга ашиглан Wi-Fi холболтыг тохируулах талаарх мэдээллийг авахын тулд дараах холбоосыг дарна уу. Энэ үзүүлэлт нь бүх бүтээгдэхүүнд ашиглагдах боломжгүй эсвэл идэвхжээгүй байж магадгүй.

 html/wps_b.htm

WPS PIN код

Утасгүй рүүтэр (хандалтын цэг) рүү найман дугаарыг оруулж тохируулгыг хийх боломжтой. Найман дугаар нь бүтээгдэхүүний LCD дэлгэц дээр гарах буюу сүлжээний төлвийн хуудас дээр хэвлэгдэх болно.

WPS тохируулга ашиглан Wi-Fi холболтыг тохируулах талаарх мэдээллийг авахын тулд дараах холбоосыг дарна уу. Энэ үзүүлэлт нь бүх бүтээгдэхүүнд ашиглагдах боломжгүй эсвэл идэвхжээгүй байж магадгүй.

 html/wps_p.htm

Шууд Холболт

Та бүтээгдэхүүнийг утасгүй рүүтэр (хандалтын цэг)-гүйгээр шууд компьютер, ухаалаг утас, таблеттэй холбох боломжтой. Таны бүтээгдэхүүн болон төхөөрөмжөөс хамаарч дараах аргуудыг хэрэглэж болно.

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

Wi-Fi Direct холболт:

Wi-Fi Direct буюу Wi-Fi-г дэмждэг төхөөрөмж ашиглан бүтээгдэхүүнд шууд холбогдох боломжтой. Энэ арга нь дэд бүтцийн горимтой адил WPA2-PSK(AES) аюулгүйн аргыг хэрэглэдэг.

[14 хуудас дээрх "Wi-Fi Direct"](#)

Ад Хок холболт:

Та Ад Хок нийцэлттэй төхөөрөмж ашиглан бүтээгдэхүүнд холбогдох боломжтой. Энэ арга нь зөвхөн WEP аюулгүйн аргыг хэрэглэдэг.

[16 хуудас дээрх "Ад хок горим"](#)

Тэмдэглэл:

- Эдгээр үзүүлэлтүүд нь бүх бүтээгдэхүүнд ашиглагдах боломжгүй эсвэл идэвхжээгүй байж магадгүй.
- Windows компьютерт програмын диск дээрх суулгагчийг ашиглан шууд холболтыг тохируулах боломжтой. Хэрэв бүтээгдэхүүн Wi-Fi Direct-ийг дэмждэг бол Wi-Fi Direct ашиглан холбогдоно.

Wi-Fi Direct

Wi-Fi Direct-д зориулсан хоёр холболтын горим бий; "Энгийн AP горим" болон төхөөрөмж хоорондын холболт болох "Wi-Fi Direct горим". Web Config дахь үйлчилгээний тохиргоог ашиглан холболтын горимыг солих боломжтой. Web Config-ыг ашиглах талаар дэлгэрэнгүйг бүтээгдэхүүний Хэрэглэгчийн Зааварчилгаанаас лавлаарай.

Энгийн AP горим (хандалтын цэгийн холболт):

Энэ горимд бүтээгдэхүүн нь хандалтын цэгийн үүрэг гүйцэтгэнэ. Таны төхөөрөмж Wi-Fi Direct-ийг дэмждэггүй байсан ч, бүтээгдэхүүнийг төхөөрөмж рүү холбох боломжтой. Энэ горимд, бүтээгдэхүүний өгөгдмөл SSID нь "DIRECT-xxxxxxx" байна (xxxxxxx нь бүтээгдэхүүний MAC хаяг).

Wi-Fi Direct горим (төхөөрөмж хоорондын холболт):

Энэ горимд, бүтээгдэхүүнийг бүлгийн эзэмшигч буюу харилцагчаар тодорхойлж холболт үүсгэгдэнэ. Хэрэв таны төхөөрөмж Wi-Fi Direct-ийг дэмждэг бол, энэ горимыг ашиглах боломжтой.

Тэмдэглэл:

- Хэрэв бүтээгдэхүүн Ад Хок горимд ажиллаж байгаа бол Wi-Fi Direct-ийг ашиглах боломжгүй.
- Бүтээгдэхүүн Wi-Fi Direct-ээр холбогдсон тохиолдолд, Web Config ашиглан фирмварийг шинэчлэх боломжгүй.
- Wi-Fi Direct холболттой төхөөрөмжөөс Web Config-ыг ажиллуулж байгаа тохиолдолд Epson Connect, Google Cloud Print зэргийг тохируулах боломжгүй.
- Windows-ийн Wi-Fi Direct үзүүлэлтийг ашигласан шууд холболт дэмжигдэхгүй.

Энгийн AP горим

Энгийн AP горимд бүтээгдэхүүн дөрөв хүртэлх сүлжээний төхөөрөмжөөс холболтыг зөвшөөрнө. Хэдэн төхөөрөмж холбогдсоныг сүлжээний холболтын тайлангаас шалгах боломжтой. Та энэ горимыг бүтээгдэхүүн дэд бүтэц буюу Этернэтэд холбогдсон үед ч ашиглах боломжтой.

Бүтээгдэхүүн Энгийн AP горимд ажиллаж байх үед, дэлгэц дээр нь Энгийн AP горимын таних тэмдэг гарна. Таних тэмдгийн хэлбэр, байрлал загвараас хамаарч ялгаатай байна. Илүү дэлгэрэнгүйг бүтээгдэхүүний Хэрэглэгчийн Зааварчилгаанаас лавлаарай.

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

Энгийн AP горимыг ашиглахаа болихыг хүсвэл, принтерийн хянах самбар буюу Web Config-аас Wi-Fi Direct-ийг цуцла.

Тэмдэглэл:

- Хэрэв Энгийн AP горимоор холбогдсон төхөөрөмжөөс холбогдвол, дэд бүтцийн буюу Этернэтийн сүлжээнд холбогдох боломжгүй болох ба бүтээгдэхүүн холбогдож байсан ч хамаагүй юм.
- Энгийн AP горимд энэ үзүүлэлтийг ашиглаж байгаа бүтээгдэхүүнд холбогдсон төхөөрөмжүүд хоорондоо харилцах функц байхгүй.
- Хэрэв холбогдож болох төхөөрөмжийн тоо хэтэрснээс болж бүтээгдэхүүнд холбогдох боломжгүй байвал, бүтээгдэхүүнийхээ SSID (DIRECT-xxxxxxx)-ээс аль нэг төхөөрөмжийг салга. Хэрэв аль төхөөрөмжүүд одоо холбогдсон байгааг мэдэхгүй бол, бүтээгдэхүүний хянах самбараас нууц үгийг өөрчлөх замаар бүх төхөөрөмжийг салга. Ингэх нь бүх төхөөрөмжийг салгахыг дахин анхаарна уу. Энэ аргаар салгагдсан төхөөрөмжийг дахин холбохын тулд, сүлжээний тохиргоог дахин хий.
- Хэрэв Wi-Fi Direct нийцэлттэй төхөөрөмж бүтээгдэхүүнд Энгийн AP горимоор холбогдохгүй байвал, Wi-Fi Direct горимоор холбо.
- Шинэчлэгдсэн Windows Үйлдлийн Системтэй компьютер холбогдох боломжгүй байж магадгүй.

Wi-Fi Direct-ийг ашиглах талаар дэлгэрэнгүйг дараах холбоосыг дарж аваарай. Энэ үзүүлэлт нь бүх бүтээгдэхүүнд ашиглагдах боломжгүй.



Ухаалаг утас буюу таблет Wi-Fi Direct-ийг дэмжих тохиолдолд

Wi-Fi Direct-ийг дэмждэг Android төхөөрөмж хэрэглэж байгаа бол, принтерийг бас Wi-Fi Direct ашиглан холбох боломжтой.

Тэмдэглэл:

Android үйлдлийн системийн хувилбар буюу загвараас хамаарч Wi-Fi Direct холболт дэмжигдэхгүй байж магадгүй. Ажиллагааны дараалал загвараас хамаарч ялгаатай байна.

- 1** Wi-Fi Direct-ийг принтер дээрээ тохируул.
Энэ алхамын талаарх илүү дэлгэрэнгүйг Wi-Fi Direct холбоосыг дарж аваарай.
- 2** Wi-Fi Direct ашиглан ухаалаг утас буюу планшетаа принтерт холбо.
Энэ алхамын талаарх илүү дэлгэрэнгүйг ухаалаг утас буюу планшетынхаа бичиг баримтаас лавлаарай.
- 3** Принтерийн хянах самбар дээрх зурвасыг шалга. Холболтыг зөвшөөрөхийн тулд зөвшөөрөхийг сонго. Холболтыг түтгэлзүүлэхийн тулд татгалзахыг сонго.
- 4** Төхөөрөмжийн мэдээллийг принтерт бүртгэх эсэхийг сонго.
Хэрэв холболтыг зөвшөөрч төхөөрөмжийн мэдээллийг бүртгэвэл, дараагийн удаагаас самбар дээрх үйлдлүүдийг гүйцэтгэх шаарлагагүйгээр төхөөрөмж принтертэй шууд холбогдоно. Хэрэв холболтыг түтгэлзүүлж төхөөрөмжийн мэдээллийг бүртгэвэл, принтер хойшид тухайн төхөөрөмжийн холболтыг түтгэлзүүлэх ба Wi-Fi Direct ашиглан холбох гэж оролдсон ч ялгаагүй байна.

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

Тэмдэглэл:

- ❑ *Хэрэв принтерийн хянах самбар дээр үл мэдэгдэх төхөөрөмж холбогдсон баталгаа олон дахин гарч ирээд байвал тухайн төхөөрөмжийг түтгэлзсэн төхөөрөмжид бүртгэхийн зөвлөж байна.*
- ❑ *Хэрэв төхөөрөмжийг санамсаргүй бүртгэчихсэн бол, хянах самбар дээрх Wi-Fi Direct тохиргооноос бүртгэсэн төхөөрөмжийн мэдээллийг устга. Энэ функцийг ашигласнаар, принтерт бүртгэгдсэн төхөөрөмжийн холболтын бүх мэдээлэл устагдана.*

Wi-Fi Direct горим

Wi-Fi Direct горимд Wi-Fi Direct-ийг дэмжих нэг төхөөрөмжийг бүтээгдэхүүнд холбох боломжтой. Wi-Fi Direct горим ашиглан сүлжээнд холбогдох үед бусад бүх сүлжээний холболтууд салгагдана. Тиймээс, Epson Connect болон бусад интернэтээр бүтээгдэхүүнд хандах функцууд ашиглагдах боломжгүй болно.

Бүтээгдэхүүн Wi-Fi Direct горимд ажиллаж байх үед, дэлгэц дээр нь Wi-Fi Direct горимын таних тэмдэг гарна. Таних тэмдгийн хэлбэр, байрлал загвараас хамаарч ялгаатай байна. Илүү дэлгэрэнгүйг бүтээгдэхүүний Хэрэглэгчийн Зааварчилгаанаас лавлаарай.

Хэрэв холболтыг таслахыг хүсвэл, бүтээгдэхүүнийг төхөөрөмжөөсөө салга. Бүтээгдэхүүн өмнөх сүлжээндээ дахин холбогдох болно.

Ад хок горим

Ад Хок горимд, бүтээгдэхүүн болон компьютер нь хандалтын цэг ашиглалгүй утасгүй холбогдоно. Ад Хок горим ашиглан холбогдохын тулд эхлээд, компьютерийн Ад Хок тохиргоо (SSID)-г тохируул.

Windows-ийн хувьд:

Бүтээгдэхүүнийг хувиар програмын дискийг компьютерт оруулаад, дэлгэцэн дээрх зааврыг дагаарай. [8 хуудас дээрх "Windows"](#) .

Mac OS X-ийн хувьд:

EpsonNet Setup-ийг ашиглан сүлжээний тохиргоог хий. [11 хуудас дээрх "Mac OS X"](#)

Тэмдэглэл:

- ❑ *Wi-Fi холболттой байсан ч, бүтээгдэхүүн болон компьютер таны орчинд холбогдох боломжгүй байж магадгүй. Гэхдээ Ад Хок холболт ашиглан тохируулах боломжтой байна. Энэ нь бүтээгдэхүүн болон компьютер хоорондын шууд холболт юм. Зөвхөн ганц компьютер холбогдох боломжтой. Бусад компьютеруудад бүтээгдэхүүнд Wi-Fi холболт хийх боломжгүй болно.*
- ❑ *Компьютерээс Ад Хокийг тохируулах аргачлал нь таны үйлдлийн систем, компьютер, утасгүй төхөөрөмжүүдийн үйлдвэрлэгчээс хамаарна. Дэлгэрэнгүйг утасгүй төхөөрөмжийн бичиг баримтаас лавлах буюу үйлдвэрлэгчийн хэрэглэгийн тусламжид холбогдоорой. Дараах хэсэгт Windows 7, Vista, XP буюу Mac OS X стандарт тохиргооны тохируулгыг тайлбарлана.*


Windows 7/Vista-ийн хувьд

- 1 Start (Эхлэл) > Control Panel (Хянах Самбар) > View network status and tasks (Сүлжээний төлөв болон ажлуудыг харгах)-ийг сонго.**

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

2 Change adapter settings (Адаптарын тохиргоог өөрчлөх) (7-д) эсвэл Manage network connections (Сүлжээний холболтыг удирдах) (Vista-д)-ийг дар.

3 Wireless Network Connection (Утасгүй Сүлжээний Холболт) таних тэмдгийг хоёр дар.




4 Windows 7-ийн хувьд: Open Network and Sharing Center (Сүлжээ болон Хамтран Ашиглах Төвийг Нээх)-ийг дараад Set up a new connection or network (Шинэ холболт буюу сүлжэг тохируулах)-ийг дар.

Windows Vista-ийн хувьд: Set up a connection or network (Холболт болон сүлжээг тохируулах)-ийг дар.

5 Set up a wireless ad hoc (computer-to-computer) network (Утасгүй ад хок (компьютер хоорондын) сүлжээ)-ийг сонгоод Next (Дараах)-ийг дар.

6 Next (Дараах)-ийг дар.

7 Дараах хүснэгтийг харж тохиргоогоо хийгээд Next (Дараах)-ийг дар.



a	<p>Network name (SSID) (Сүлжээний нэр (SSID)): дараах тэмдэгтүүдийг ашиглан дурын нэрийг оруул.</p> <p>0123456789 !"#%&'()*+,-./:; ABCDEFGHIJKLMNOPQRSTUVWXYZ abcdefghijklmnopqrstuvwxyz [¥]^_`{ }~<=>?@</p>
---	---

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

b	Security type (Аюулгүй байдлын төрөл): WEP-ийг сонго.
c	Security key (Аюулгүй байдлын түлхүүр): 5 буюу 13 ASCII тэмдэгт ашигласан үг (жишээ нь еrson), эсвэл 10 буюу 26 арван зургаатын тэмдэгтийг оруул.
d	(Windows 7/Vista) Save this network (Энэ сүлжээг хадгалах): энэ чагтлах хайрцгийг сонго.


- 8** Close (Хаах)-ийг дар.
- 9** Wireless Network Connection (Утасгүй Сүлжээний Холболт) таних тэмдгийг хоёр дар.
- 10** Ад Хок холболт бүргэгдсэн эсэхийг магадлаад, **appropriate place on the Desktop (Нүүр дэлгэц дээрх тохиромжтой байрлал)** (7-д) эсвэл **Cancel (Цуцлах)** (Vista-д)-ийг дар.

Тэмдэглэл:
Сүлжээний нэр (SSID)-ийг сонгоход **Connect (Холбогдох)** товч ирвэл **Connect (Холбогдох)**-ийг дар.

Windows XP-ийн хувьд

- 1** Start (Эхлэл) > Control Panel (Хянах Самбар) > Network and Internet Connections (Сүлжээ болон Интернетийн Холболт)-ийг сонго.
- 2** Network Connections (Сүлжээний Холболт)-ийг дар.
- 3** Wireless Network Connection (Утасгүй Сүлжээний Холболт)-ийг баруун товчоор дарж, Properties (Шинж чанар)-ийг сонгоод Wireless Networks (Утасгүй Сүлжээ) табыг дар.


Тэмдэглэл:
Хэрэв утасгүй төхөөрөмжтэй дагалдаж ирсэн хэрэглүүрийг ашиглаж байгаа бол **Wireless Networks (Утасгүй Сүлжээ)** таб гарч ирэхгүй байж магадгүй. Илүү дэлгэрэнгүйг утасгүй төхөөрөмжийн бичиг баримтаас лавлаарай.



- 4** Use Windows to configure my wireless network settings (Windows ашиглан утасгүй сүлжээний тохиргоог тохируулах)-ийг сонгоод **Advanced (Мэргэшсэн)**-ийг дар.

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

- 5 Computer-to-computer (ad hoc) networks only (Зөвхөн компьютер хоорондын (ад хок) сүлжээ)**-ийг сонго.
- 6 Automatically connect to non-preferred networks (Давуу эрхгүй сүлжээ рүү автоматаар холбогдох)**-ийг арилгаад **Close (Хаах)**-ийг дар.
- 7 Add (Нэмэх)**-ийг дар.
- 8** Дараах хүснэгтийг харж тохиргоогоо хийгээд **OK**-ийг дар.




a	Network name (SSID) (Сүлжээний нэр (SSID)): дараах тэмдэгтүүдийг ашиглан дурын нэрийг оруул. 0123456789 !"#\$%&'()*+,-./:; ABCDEFGHIJKLMNOPQRSTUVWXYZ abcdefghijklmnopqrstuvwxyz [¥]^_`{ }~<=>?@
b	Security type (Аюулгүй байдлын төрөл): WEP-ийг сонго.
c	Security key (Аюулгүй байдлын түлхүүр): 5 буюу 13 ASCII тэмдэгт ашигласан үг (жишээ нь ерson), эсвэл 10 буюу 26 арван зургаатын тэмдэгтийг оруул.
d	(Windows XP) The key is provided for me automatically (Түлхүүр автоматаар олгогдсон): энэ хайрцгийг арилгаад аюулгүйн түлхүүрийг оруул.
e	(Windows XP SP3) Connect even if this network is not broadcasting (Энэ сүлжээ өргөн цацалт хийгээгүй үед ч холбогдох): энэ чагтлах хайрцгийг сонго.

- 9 Connection (Холболт)** табыг дар.
- 10 Connect when this network is in range (Энэ сүлжээ ойрхон үед холбогд)**-ийг сонгоод **OK**-г дар.
- 11 Wireless Network Connection (Утасгүй Сүлжээний Холболт)**-ийг баруун товчоор дарж, **Properties (Шинж чанар)**-ийг сонгоод **Wireless Networks (Утасгүй Сүлжээ)** табыг дахин дар.


Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

- 12 Таних тэмдэгт цэнхэр тойрог байгаа эсэхийг шалгаад **OK**-г дар.



Mac OS X-ийн хувьд

- 1 Apple Цэснээс **System Preferences**-ийг сонго.
- 2 **Network** таних тэмдгийг дар.
- 3 **AirPort**-ийг сонгоод **Turn AirPort On**-ийг дар.



- 4 **Network Name** жагсаалтаас **Create Network**-ийг сонго.
- 5 Сүлжээний нэрийг оруулаад **Require Password** чэгтлэх хайрцгийг сонго.
- 6 Нууц үгийг оруулаад **OK**-г дар.
- 7 **Advanced**-ийг дар.

Бүтээгдэхүүнийг Сүлжээгээр Ашиглах

- 8 **TCP/IP**-ийг дар.
- 9 **Configure IPv4** жагсаалтаас **Using DHCP**-ийг сонгоод **OK**-г дар.
- 10 **Apply**-ийг дар.

Асуудал шийдвэрлэх

Сүлжээний Асуудлыг Шийдэх Зөвлөгөө

Сүлжээний асуудлууд нь сүлжээний орчин, компьютер болон бүтээгдэхүүнээс үүднэ. Асуудлыг шийдвэрлэхэд тусламж болгон, дараах аргыг ашиглан сүлжээний төлвийг шалгаж магадлах боломжтой.

Тэмдэглэл:

Сүлжээний тохиргоонд өөрчлөлт хийгдэхэд, тохируулгын өөрчлөлтийг хэрэгжтэл 30-аас 60 секунд орно.

(Өөрчлөлт хэрэгжих хүртэл орох хугацаа нь тохиргооны арга, утасгүй рүүтэ, хандалтын цэг зэргээс шалтгаална.)

Сүлжээний холболтын шалгалтын тайланг хэвлэх

Хэрэв та сүлжээний орчинг өөрчлөх зэргээр сүлжээний тохиргоонд өөрчлөлт хийвэл, сүлжээний холболтыг шалган сүлжээний холболтын тайланг хэвлэх боломжтой.

Хэрэв сүлжээний холболт амжилтгүй болвол, шалгалтын тайлан танд асуудлыг шийдэхэд туслана.

Хэрхэн сүлжээний холболтыг шалгах болон шалгалтын тайланг хэвлэх талаар дэлгэрэнгүйг бүтээгдэхүүнийхээ бичиг баримтаас лавлаарай.

Тэмдэглэл:

Энэ үзүүлэлтийг LCD дэлгэцгүй бүтээгдэхүүн дээр ашиглах боломжгүй.

Сүлжээний холболтын шалгалтын тайланг ашиглах талаар мэдээллийг дараах холбоосыг дарж аваарай.

Энэ үзүүлэлт нь бүх бүтээгдэхүүнд ашиглагдах боломжгүй эсвэл үзүүлэлт идэвхижээгүй байж магадгүй.

 html/_files/nwchk.htm

Сүлжээний төлвийг гаргах болон сүлжээний төлвийн хуудсыг хэвлэх

Та сүлжээний төлвийг LCD дэлгэц дээр гаргах, мөн сүлжээний төлвийн хуудсыг хэвлэх боломжтой. Сүлжээний төлөвт та холболтын арга, холболтын хурд (дамжуулах хурд), IP хаяг, аюулгүйн арга болон Epson Connect төлөв зэргийг магадлах боломжтой.

Хэрэв таны бүтээгдэхүүн LCD дэлгэцтэй бол, хялбаршуулсан төлвийн мэдээллийг дэлгэцэнд гаргаж дэлгэрэнгүй мэдээллийг хэвлэх боломжтой. Энэ үзүүлэлт нь бүх бүтээгдэхүүнд ашиглагдах боломжгүй.

Асуудал шийдвэрлэх

Хэрэв таны бүтээгдэхүүн LCD дэлгэцгүй бол, хянах самбарын товчийг ашиглан дэлгэрэнгүй төлвийн мэдээллийг хэвлэх боломжтой.

Сүлжээний төлвийг харуулах болон сүлжээний төлвийн хуудсыг хэвлэх талаар дэлгэрэнгүйг бүтээгдэхүүнийхээ бичиг баримтаас лавлаарай.

Wi-Fi тохиргоог цуцлах болон эхлүүлэх

Wi-Fi тохиргоог цуцлаж, эхлүүлэн, тохиргоог дахин хийснээр сүлжээний асуудал шийдэгдэх боломжтой байж магадгүй.

Эдгээр үйлдлүүд нь загвараас хамаарч ялгаатай байна. Илүү дэлгэрэнгүйг бүтээгдэхүүнийхээ бичиг баримтаас лавлаарай.

Тэмдэглэл:

Wi-Fi тохиргоог цуцлаж эхлүүлэхийн өмнө, SSID болон нууц үгийг магадлан бичиж авахыг зөвлөж байна.

Wi-Fi функцыг цуцлах:

Хэрэв таны бүтээгдэхүүн LCD дэлгэцтэй бол, LCD дэлгэцийг ашиглан Wi-Fi функцыг цуцлах буюу Этернэт рүү солих боломжтой.

Хэрэв таны бүтээгдэхүүн LCD дэлгэцгүй бол, идэвхтэй сүлжээнд холбогдсон Этернэтийн кабелиг холбон Wi-Fi функцыг цуцлах боломжтой.

Хэрэв таны бүтээгдэхүүн LCD дэлгэц болон Этернэтийн интерфэйсгүй бол, хянах самбарын товчийг ашиглан сүлжээний тохиргоог эхлүүлэх замаар Wi-Fi функцыг цуцлах боломжтой.

Тэмдэглэл:

Хэрэв таны бүтээгдэхүүн Этернэт болон Wi-Fi функцтай бол, Wi-Fi функц цуцлагдсан үед Этернэтийн функц идэвхжих болно.

Сүлжээний тохиргоог эхлүүлэх:

Хэрэв таны бүтээгдэхүүн LCD дэлгэцтэй бол, LCD дэлгэцийг ашиглан сүлжээний тохиргоог эхлүүлэх боломжтой.

Хэрэв таны бүтээгдэхүүн LCD дэлгэцгүй бол, хянах самбарын товчийг ашиглан сүлжээний тохиргоог эхлүүлэх боломжтой.

Тэмдэглэл:

Хэрэв та сүлжээний тохиргоог эхлүүлвэл, Epson Connect тохиргоо болон бусад компанийн сүлжээний хэвлэх үйлчилгээний тохиргоонууд бас эхлэгдэх болно.

Бүтээгдэхүүний фирмварийг шинэчлэх

Бүтээгдэхүүний фирмварийг шинэчлэснээр сүлжээний асуудлууд шийдэгдэж магадгүй. Бүтээгдэхүүний хамгийн сүүлийн үеийн фирмварийг хэрэглэж байгаа эсэхээ магадла.

Вэб хөтөч ашиглан Web Config-ыг нээгээд фирмварийг шинэчил.

Асуудал шийдвэрлэх

Тэмдэглэл:

Энэ үзүүлэлт нь бүх бүтээгдэхүүнд ашиглагдах боломжгүй эсвэл идэвхжээгүй байж магадгүй.

Web Config-ыг нээх талаар илүү дэлгэрэнгүйг бүтээгдэхүүний Хэрэглэгчийн Зааварчилгаанаас лавлаарай.

Холболтыг Пинг команд ашиглан шалгах

Хэрэв та бүтээгдэхүүнд суугдсан Вэб хуудсанд хандах боломжгүй байвал, бүтээгдэхүүнд хэвлэх ажил илгээсэн ч хариу өгөхгүй байвал, мөн бусад өөр асуудлууд гарвал, энэ үзүүлэлтийг ашиглан компьютер болон бүтээгдэхүүний хооронд холболт үүсгэгдсэн эсэхийг магадла.

